



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/312

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн  
төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 30 дугаар зүйлийн 30.1, 30.4, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.3, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2.6, Засгийн газрын 2017 оны “Захиалагчийн дүрэм батлах тухай” 170 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг-2024” А/259 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр батлагдсан Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажлыг үргэлжлүүлэх /Ренчинлхүмбэ/ ажлыг гүйцэтгэгч сонгох ХӨАХААГ/20240101081/ дугаартай 200,083,096 (Хоёр зуун сая наян гурван мянга ерөн зургаа) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Ти Эйч Ти Эн” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Ти Эйч Ти Эн” ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, ажлын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, шаардлага хангасан гэрэлтүүлэг тавих аюулгүй байдлыг ханган ажиллах ажлын үе шатны хяналт хэрэгжүүлэх этгээдтэй гэрээ байгуулах дүгнэх, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх чиг үүрэг бүхий захиалагчийн төлөөлөгч, ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Б.Оюунтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хөрөнгө  
оруулалтын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

О.Энхтүвшин

(Ренчинлхүмбэ сумын Засаг даргын  
Тамгын газрын дарга)

Б.Цэнддэлгэр

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын  
өмчийн бүртгэл ашиглалт хариуцсан  
ахлах мэргэжилтэн)  
("Ти Эйч Ти Эн" ХХК-ийн захирал)

Д.Энхтүвшин

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Д.Сандагдорж

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн дэд бүтцийн  
бодлого үйл ажиллагааг зохион

d/A4


6712010978

3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр батлагдсан Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажлыг үргэлжлүүлэх /Ренчинлхүмбэ/ ажлыг гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлд үе шатанд хийх захиалагчийн хяналтыг "Ти Эйч Ти Эн" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх, уг гэрээг дүгнэх, ил далд ажлын акт, барилгын ажлын гүйцэтгэлийг тус тус баталгаажуулах, барилга байгууламжийг ашиглалтад оруулахад шаардлагатай баримт бичгийг бэлтгэж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэх, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн тайлан барилга байгууламжийн ажлын гэрээний хэрэгжилттэй холбоотой баримт бичгийг архивын нэгж болгон Худалдан авах ажиллагааны газрын архивт шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээт ажлын үе шатны хяналтыг хийж, баталгаажуулсан техник хяналтын нэгдсэн дүгнэлт, зохиогчийн дүгнэлт, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр архивлан тус газрын архивт шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ж.Адьяасүрэн)-д тус тус даалгасгай.

4. Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажлыг үргэлжлүүлэх /Ренчинлхүмбэ/ ажлын гүйцэтгэгч сонгоход хэрэгжүүлэх шаардлагатай зардлыг гэрээний дагуу "Ти Эйч Ти Эн" ХХК-т Ренчинлхүмбэ сумын шаардлага хангасан гэрэлтүүлэг тавих аюулгүй байдлыг хангах ажлыг үргэлжлүүлэх ажлын гүйцэтгэгч шинэчлэлтийн ажлыг ашиглалтад хүлээн авах ажиллагаатай холбогдон гарах зардлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт шилжүүлэхийг Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог)-т тус тус зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ